

“АЯНЧИН ФООР СИЙЗОНЗ ЛОДЖ” ХХК

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРЭГ,
ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН “ЭРЭЭНИЙ АДАГ” НЭРТЭЙ ГАЗАР ХЭРЭГЖИЖ
БУЙ “АЯНЧИН ЛОДЖ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2024 он

**БАТЛАВ. ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА**

/М.ЭРДЭНЭБУЛГАН/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН

“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Г.БИЛГҮҮН/

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРЭГ,
ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН “ЭРЭЭНИЙ АДАГ” НЭРТЭЙ ГАЗАР ХЭРЭГЖИЖ
БУЙ “АЯНЧИН ЛОДЖ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 2872595 /

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙЦААГЧ / МЭРГЭЖИЛТЭН

/ /

БОЛОВСРУУЛСАН:

“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК-ийн

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН

/О.ӨНӨРЖАРГАЛ/

Улаанбаатар хот

2024 он

“АЯНЧИН ФООР СИЙЗОНЗ ЛОДЖ” ХХК

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРЭГ,
**ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
“ЭРЭЭНИЙ АДАГ” НЭРТЭЙ ГАЗАР ХЭРЭГЖИЖ БУЙ “АЯНЧИН
ЛОДЖ” ЖУУЛЧНЫ БААЗЫН**
**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС**

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙЦААГЧ/ МЭРГЭЖИЛТЭН

/ /

БОЛОВСРУУЛСАН:

“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК-ийн

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН

/О.Өнөржаргал/

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

ОРШИЛ.....

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....

- 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....
 - 1.1.1. Төслийн нэр
 - 1.1.2. Төслийн байршил.....
 - 1.1.3. Төсөл хэрэгжүүлэгч
 - 1.1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг
 - 1.1.5. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт.....
 - 1.1.6. Талбайн байршил
- 1.2. Баазын хүчин чадал, үндсэн барилга байгууламж

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....

БҮЛЭГ III. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....

- 3.1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- 3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....
 - 3.2.1. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
 - 3.2.2. Жуулчны баазын өмнө гүйцэтгэсэн ногоон байгууламж**
 - 3.2.3. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- 3.2.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....**
- 3.2.5. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
- 3.2.6. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
- 3.2.7. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө.....
- 3.3. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө
- 3.4. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- 3.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....
- 3.6. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

ОРШИЛ

“Аянчин Лодж” жуулчны бааз нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6 дугаар хороо, Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Эрээний адаг нэртэй газарт 12 га талбайд хэрэгжиж байна. Тус амралт, жуулчны бааз хүртэл Улаанбаатар хот засмал замаар холбогдсон. Улаанбаатар хотоос 51.3 км, Налайх дүүгээс 15 км зайд оршино. Улаанбаатар - Тэрэлжийн төв засмал замаас салаад сайжруулсан шороон замаар 0.6 км явж хүрдэг.

Жуулчны бааз нь өвлийн улиралд нэг ээлжиндээ 28 хүн, зуны улиралд 78 хүн, жилд дундажаар 4250 хүн хүлээн авах хүчин чадалтай. Баазын үндсэн байгууламжид 2 давхар термоблок бетонон байшин 1 ш, 2 давхар гэр-тек модон байшин 1 ш, гэр булийн 4 хаус, зуны модон байшин 8 ш, америк гэр 5ш, монгол гэр 5 ш, бага оврын цэвэрлэх байгууламж, бохир усан сан, гүний худаг, хүүхдийн тоглоомын талбай, автомашины граж, ажилчдын байраас бүрдэнэ. Бааз нь жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 11 хүн ажилладаг.

“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК-ийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан гүйцэтгэлээ. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 4 дүгээр хэсгийг баримтлан шинэчлэн боловсруулав.


БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1. Төслийн нэр	“Аянчин Лодж” жуулчны бааз
1.1.2. Төслийн байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6 дугаар хороо, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Эрээний адаг нэртэй газарт 12 га талбайд хэрэгжиж байна. <i>/Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах тоот гэрчилгээний хуулбарыг хавсаргав/.</i>
1.1.3. Төсөл хэрэгжүүлэгч	“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК, РД: 2872595, Улсын бүртгэлийн дугаар 2911001070, <i>/Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав/</i>
1.1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6 дугаар хороо, утас: 99094539
1.1.5. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт	Жуулчны бааз нь өвлийн улиралд нэг ээлжиндээ 28 хүн, зуны улиралд 78 хүн, жилд дунджаар 4250 хүн хүлээн авах хүчин чадалтай. Баазын үндсэн байгууламжид 2 давхар термоблок бетонон байшин 1 ш, 2 давхар гэр-тек модон байшин 1 ш, гэр бүлийн хаус 4 ш, зуны модон байшин 8 ш, америк гэр 5ш, монгол гэр 5ш, бага оврын цэвэрлэх байгууламж, бохир усан сан, гүний худаг, хүүхдийн тоглоомын талбай, автомашины граж, ажилчдын байраас бүрдэнэ. Бааз нь жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 11 хүн ажилладаг.

1.1.6. Талбайн байршил

Тус амралт, жуулчны бааз хүртэл Улаанбаатар хоттой засмал замаар холбогдсон. Улаанбаатар хотоос 51.3 км, Налайх дүүгээс 15 км зайд оршино. Улаанбаатар-Тэрэлжийн төв засмал замаас салаад сайжруулсан шороон замаар 0.6 км явж хүрдэг.



Зураг №1. Төсөл хэрэгжисж буй талбайн байршилын тойм зураг

Тус бааз нь Байгаль орчин, Аялал жуулчлалын яамнаас 2017 оны 09 сарын 07-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт ачлал жуулчлалын зориулалтаар газар ашиглах 0160853 дугаартай гэрчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 09 сарын 07 өдрийн А/263дугаартай тушаалаар 5 жилийн хугацаатай авсан.

Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах талбайн булангийн цэгүүдийн солбицлыг хүснэгт № 1-д үзүүлэв.

Жуулчны баазын талбайн булангийн цэгүүдийн солбицол

Хүснэгт №1.

Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Булангийн цэгүүдийн дугаар	Уртраг			Өргөрөг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
19/299	12	1	107	23	50.935	47	51	37.085
		2	107	24	11.012	47	51	41.821
		3	107	24	18.288	47	51	40.981
		4	107	24	19.336	47	51	34.022
		5	107	24	12.176	47	51	31.420
		6	107	23	52.664	47	51	34.603

Тус байгууллага нь 2017 оны 09 сарын 25-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээг Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай гурвалсан гэрээг 2027 оны 09 сарын 07-ны өдөр хүртэл хугацаагаар хийсэн. /Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээний хуулбарыг хавсаргав./

1.2. Баазын хүчин чадал, үндсэн барилга байгууламж

“Аянчин Лодж” жуулчны бааз 2005 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд бааз нь одоогоор дараах барилга байгууламж, хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Үндсэн байгууламж: 2 давхар термоблок бетонон барилга орох бөгөөд 1 дүгээр давхарт ресторан, хурлын танхим, ресепшин, гал тогоо, боловсон ариун цэврийн өрөө, 2 дугаар давхарт 5ш зочид буудлын өрөөтэй.



Зураг № 2. 2 давхар термоблок бетонон барилга



Зураг № 3. Баазын ресторан, гол тогтоо, хурлын танхим



Зураг № 4. Зочил буудлын жижиг өрөө


Зоорийн давхар тоглоомын өрөө (теннис, пүүсболл), хүүхдийн тоглоомын өрөө (зураг зурах, тоглох), караоке, агуулах, бие засах газар байрлана.



Зураг № 5. Тоглоомын өрөө, хүүхдийн тоглоомын өрөө, караоке

Гэр-тек модон барилга: Тус барилгын 1 дүгээр давхарт 3 ш зочид буудлын өрөө, 2 дугаар давхарт 4 ш зочид буудлын өрөө, зоорийн давхарт 6 ш ажилчдын өрөө, өрөө тус бүр нь бие засах өрөөтэйгээс гадна техникийн өрөө болон цэвэр усны ёмкость байрлуулаж өгсөн.





Зураг № 7. Зочил буудлын өрөө

Оффисын барилга: Тус барилгын дээд давхарт баазын удирдлагын байр, доор нь оффисын өрөө байрлана.



Зураг № 8. Оффисын барилга

Гэр булийн зориулалттай хаус: Гэр булийн зориулалттай зочны хаус нь тус бүр 2 унтлагын өрөө, ариун цэврийн өрөө, зочны – зоогийн өрөөтэйгээс гадна үүдэндээ нарлах, гадна суух тавцантай.



Зураг № 9. Баазын гэр бүлийн амралтын байшин

Зуны байшин, гэр: Жуулчны баазад зуны модон байшин 8 ш, америк гэр 5 ш, 4 ханатай иж бүрэн гэр 5 ш байна.



Зураг № 10. Баазын зуны америк гэр буудал



Зураг № 11. Баазын зуны модон байшин, гэр буудал



Зураг № 12. Модон байшигийн дотор тал



Зураг № 13. Гэр бүлийн байшингийн дотор тал

Баазын гадна байгууламж: Жуулчны баазын гадна байгууламжид гадна хүүхдийн тоглоомын талбай, 25 т-ын бохир усан сан, хог хаягдлын цэг, гүний худаг, ус зайлцуулах суваг, генератор, 12 ш автомашины гараж тус тус байрлана.



Зураг № 14. Баазын гадна байгууламжсууд
/гадна хүүхдийн тоглоомын талбай, 25 т-ын бохир усан сан, хог хаяглын цэг, гүний худаг,
ус зайлцуулах суваг, генератор, 12 ш автомашины гаражс/

2020 онд манай компани “НОРБРУ” ХХК –аар 159 м² талбай бүхий герман технологийн “HSH” үйлдвэрийн угсармал модон байшинг бариулсан.

Энэ нь жуулчны базын жуулчид, амрагч нарын тав тух хангахад зориулсан усан бассейн, спортын өрөө бүхий барилга байх юм.

1.3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Уур амьсгал. Тэрэлжийн “Аянчин Лодж” цогцолбор нь Хэнтийн нуруунаас эх авсан үзэсгэлэнт Тэрэлжийн аялал жуулчлалын хүрээнд далайн түвшинээс 1650 м орчим өргөгдсөн.

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс, хахир ширүүн Хэнтийн нурууны өвөр талын уул хөндийн цаг агаарын шинжтэй, хавар намартаа сэргүүн, өвөлдөө хүйтэн уул хөндийн салхины жавартай жиндүү, зуны улирал харьцангуй богино чийглэг-хүйтэн уур амьсгалтай.

Бааз орчимд үнэмлэхүй бага температур өвөл хамгийн хүйтэн -41°C, хоногийн дундаж температур 11-14°C, үнэмлэхүй их температур 33-37°C тус тус ажиглагдаж температурын

агууриг 78°C хүрсэн. Хөрсний температур цасан бүрхүүлтэй өвлийн улиралд агаарынхаас 5-7°C хүйтэн, дулаан улиралд 5-7°C халуун байдаг.

Агаарын даралт жилдээ Улаанбаатар хот орчмоос 10-20 гПа-аар бага 840 гПа, зуны саруудад буурч 830-835 гПа, өвлийн саруудад тогтвортой өсөж 845-850 гПа хүрч байна.

Нийт хур тунадасны 75% нь зуны 3-8 саруудад орох бөгөөд жилд дунджаар 250-300 мм хур тунадас байна. Агаарын харьцангуй чийгшил 76% хүрнэ, агаар дахь усны уур буюу үнэмлэхүй чийгшил жилд дунджаар 4-5.5 гПа, өвлийн улиралд 0.8-1.3 гПа, зуны улиралд 8-11 гПа болдог.

Салхины ноёлох чиглэл уул хөндийн онцлогтой. Өдрийн цагт Туул голын хөндийгөөс, шөнийн цагт уулын өндөрлөгөөс хөндий рүү чиглэлтэй салхи ноёлно. Салхины зонхилох чиглэл нь баруун, баруун хойд, хойд зүгээс байх бөгөөд салхины дундаж хурд 2.4-4.9 м/с хүрдэг.

Хөрсөн бүрхэвч. Төслийн талбайн орчмын хөрсөн бүрхэвчид уулын ойн ширэгт бараан хөрс, уулын хар шороон хөрсний хэв шинж зонхилох бөгөөд ялзмагт давхрагын зузаан харилцан адилгүй, дов толгодын орой хэсэгт 2.1-2.4%, жалга судаг дагаж нугажсан өтгөн өвстэй газар 5-5.4%, дунджаар 3.6%-ийн ялзмагтай байна.

Жуулчны баазын талбайд хөрсний төлөв байдлыг тодруулж үнэлгээ өгөх зорилгоор 2017 оны 5 сарын 05 өдөр хээрийн судалгаа хийсэн. Үүнд хөрсний гадаргын төлөв байдал өөрчлөлт, хөрсний үе давхрагын морфологи шинж чанар, хөрсөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулан хөрсний хими, физик шинж чанарын төлөв байдлыг тодруулах зорилгоор 2 дээж авч ШУА, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид шинжлүүлсэн.

Шинжилгээгээр хөрсний дээд давхаргад агуулагдах ялзмагийн хэмжээ 8.35-15.92%, хөнгөн шавранцар хөрсөнд арай илүү агуулагдаж, хөрсний урвалын орчин ерөнхийдөө саармаг буюу 6.62-6.74 мг-экв/100г байна. Хөрсөн эх ширхэгийн бүрэлдэхүүний нунтаг шорооны агууламжийг авч үзэхэд хөнгөн шавранцар хөрсөнд дунд ширхэгтэй элс 2-0.05 мм-т 54.4-55.5%, бүдүүн тоос 0.05-0.002 мм-т 30.8-33.1%, шавар<0.002 мм-т 11.4-15.8% хэмжээтэй байна.

Дээрхээс үзэхэд тухайн хөрс үржил шимийн шинж чанараараа сайн, эрдэс болон шим тэжээлийн бодисоор хангамжтай сайн байна.

Ургамлан нөмрөг. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь ургамал газарзүйн мужлалаар Евроазийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрог, Евроазийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн хошууны Өрнөд Хэнтийн уулын хээрийн тойрог, Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрог, Улзын уулын хээрийн тойрогт хамарагдана.

Тус нутагт ургамалжилтын босоо бүслүүрийн өндөр уул, ойн, уул хээр гэсэн 3 үндсэн бүслүүр зонхилно. Судалгааны дүнгээс үзэхэд 85 овгийн 389 төрөлд хамарагдах 1229 зүйл гуурст дээд ургамалтай болохыг тогтоосон байна.

Тухайн нутаг нь уул нуруу, хотгор гүдгэр, гол шанд ихтэй учраас ургамал нь экологийн янз бүрийн нөхцөлд, янз бүрийн орчинд ургаж байдаг. Тухайлбал: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт ургаж байгаа 1229 зүйл ургамлаас хээрийн 455 зүйл, ойн 503

зүйл, нугын 454, намгийн 145, тундрийн 185, хад асганы 114, усны болон голын эрэг хавийн 101, хужир мараатай газрын 19, хөл газрын 49 зүйл ургамал тус тус ургаж байна.

Мөн тухайн нутгийн ургамлын аймгийн зүйлийн бүрдлийг амьдралын хэлбэрээр авч үзвэл олон наст 954 зүйл буюу бүх ургамлын 78.2 хувийг эзлэх бөгөөд 29 зүйл, сөөг 71, хагас сөөг 12, сөөгөнцөр 15, хагас сөөгөнцөрхөн 9, нэг наст 94, хоёр наст 29, усны ургамал 16 зүйлтэй.

Амьтны аймаг. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар 6 баг, 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй зүйл буюу манай орны хөхтний зүйлийн 40 шахам хувьтай тэнцэх хөхтөн амьтан бий. Хөхтнөөс шавьж идэштэн 5, сарьсан далавчтан 4, туулай хэлбэртэн 4, мэрэгчид 4, мэрэгчид 19, мах идэштэн 13, туурайтан 5, мөлхөгч 1 байгааг судлаачид тогтоосон байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын ойн хортон шавьжийн зүйлийн бүрэлдэхүүнд 7 баг, 114 зүйл шавьж бүртгэгдээд байна.


Хэнтийн нуруунд нийт 253 зүйл шувуу бүртгэгдсэн байдгаас 180 зүйл нь өндөглөж зусдаг. Судалгаанд хамрагдсан нутагт 37 овогт хамаарах 149 зүйл шувууг бүртгэгдсэний дотор 121 зүйл нь өндөглөж зусдаг зүйл байна.

Биогеографийн хувьд судалгаа хийсэн нутгийн жигүүртний аймагт палеарктик 45%, зүүн палеарктик 30%, голарктик 17% эзэлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа нь 295981.5 га талбай бүхий газар нутгийг хариуцан хамгаалдаг. Үүний 292905.5 га нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар, 3076 га нь Нагалхааны байгалийн нөөц газар юм. Байгалийн өвөрмөц тогтоц, биологийн төрөл зүйл, экосистемийн онцлог төрх, түүх соёлын өв, нийслэл Улаанбаатар хотын ундны цэвэр усны нөөцийг хамгаалах зорилготой байгуулагдсан. Тус газрыг УИХ-ын 1993 оны 83-р тогтоол, Засгийн газрын 1994 оны 9-р тогтоолоор Горхи-Тэрэлжийн БЦГ-ыг байгуулж, улсын тусга хамгаалалттай газрын сүлжээнд авсан байна.

“Аянчин Лодж” жуулчны бааз нь Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6 дугаар хороо, Горхи –Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Эрээний адаг нэртэй газарт 12 га талбайд хэрэгжиж байна.

Нийгэм, эдийн засаг. “Аянчин Лодж” жуулчны бааз нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэр Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Эрээний адаг нэртэй газарт хэрэгжиж байна. Тус жуулчны бааз хүртэл Улаанбаатар хоттой засмал замаар холбогдсон. Улаанбаатар хотоос 51.3 км, Налайх дүүгээс 15 км зайд оршино. Улаанбаатар - Тэрэлжийн төв засмал замаас салаад сайжруулсан широон замаар 0.6 км явж хүрдэг. Энэхүү замын засварыг жил бүр өөрийн хөрөнгөөр засаэ сайжруулдаг.



Зураг № 15. Бааз хүрэх замын засварын ажил

Горхи Тэрэлжийн тусгай хамгаалалттай бүс нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй жуулчны баазуудаас гадна хүүхдийн зуны зуслан, хэд хэдэн байгууллагын ажилчдын амралтын газрууд байрладаг

Жуулчны баазад хамгийн ойр орших суурин газар нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн төв юм. Тус дүүрэг нь нийслэлээс зүүн урагш 33 км-т оршдог, 9 дүүргийн нэг бөгөөд 7 хороотой. Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 68.7 мян.га ба 37715 хүн амтай.

Дэд бүтэц харьцануй сайн хөгжсөн, Улаанбаатар хоттой төмөр зам, авто замаар холбогдсон, дулааны хангамж цэвэр усны найдвартай эх үүсвэртэй Монгол улсын зүүн өмнөт хэсгийг хангах 220 квт цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам, холбооны шилэн кабель, дайран өнгөрдөг эдийн засгийн зангилаа нутаг юм. Улаанбаатар хотын цэвэр усны дээд эх үүсвэртэй шууд холбогдсон. Олон улсын болон хот хоорондын электрон АТС-тэй, электрон шуудан интернэтийн сүлжээ, мобиком, скайтел гар утасны сүлжээнд орсон 60 гкал- цаг дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай дулааны станцтай. Дэлхийн аль ч улс оронтой богино хугацаанд харилцаа холбоо бүрдсэн дүүрэг юм.

Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхийг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, нүүрс, алт, цагаан тугалга, болор, шохой, рашаан ус этийн ургамал, элс, шавар, хайрга зэрэг байгалийн баялаг ихтэй зэрэг давуу тал олонтой дүүрэг юм.

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын “Эрээний адаг” нэртэй газар хэрэгжиж буй “Аянчин Лодж” жуулчны баазын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг “Грийн Ассесмент” ХХК боловсруулж БОНХАЖЯ /хуучин нэрээр/-аар 2016 оны 04 сард батлуулсан байна. Нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланд тусгаснаар төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Газрын гадарга, хэвлүү. Төслөөс газрын гадарга, хэвлүүд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь баазын үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа эзэмшийн 9 га талбайн газрын гадарга техноген үйл ажиллагаанд өртөгдөж болзошгүй юм.

Агаарын чанар. Төслөөс агаарын чанарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь баазад ирсэн жуулчид хог хаягдлыг замбараагүй хаях, хог хаягдлын цэг болон цэвэрлэх байгууламжаас орчинд эвгүй үнэр гарах, амьдрах орчны тав тухыг алдуулах зэрэг болно.

Хөрсөн бүрхэвч. Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа 9 га талбайд хүний хөдөлгөөнийг хязгаарлаагүйгээс хөрсөн бүрхэвч эвдрэлд орох, талхлагдах, цахилгаан тасарсан үед ашиглах зориулалт бүхий дизель эх үүсвэрээс шатах тослох материал алдагдсанаар хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх, жуулчны баазад ирсэн зочдын хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвч талхлагдах, эвдрэлд орох зэрэг болно.

Гадаргын болон газрын доорх ус. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усны нөөц болон чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь гүний худагт худгын тоолуур тавиагүйгээс их хэмжээний усыг хяналтгүй ашиглах, нөөцөд нөлөөлөх асуудал бөгөөд болзошгүй сөрөг нөлөөлөл нь бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдсанаар хөрсөн бүрхэвчээр дамжин хөрсний усанд нөлөөлөх, бохир усыг тухай бүрд нь тээвэрлэж зайлцуулаагүйгээс бохирын цооног халих, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөгт нөлөөлөх, худгийн эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс худаг бохирдох зэрэг болно.

Ургамлан нөмрөг. Баазын үйл ажиллагааг явуулах үед орчны ургамлан бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа 9 га талбайд хүний хөдөлгөөнийг хязгаараагүйгээс ургамлан нөмрөг халцрах, талхлагдах, гадна талбайд хадгалж буй дизель түлш алдагдсанаар хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлөх, бохир усыг тухай бүрд нь тээвэрлэж зайлцуулаагүйгээс бохирын цооног халих, улмаар хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлөх зэрэг болно.,

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг. Тус жуулчны бааз нь Тус бааз нь Байгаль орчин, Аялал жуулчлалын яамнаас 2017 оны 09 сарын 07-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт ачлал жуулчлалын зориулалтаар газар ашиглах 0160853 дугаартай гэрчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 09 сарын 07 өдрийн A/263дугаартай тушаалаар 5 жилийн хугацаатай авсан ба 2023 оны 09 сарын 25-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээг Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай турвалсан гэрээг 2027 оны 09 сарын 07-ны өдөр хүртэл хугацаагаар хийсэн байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлс. Төслийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор илрэхийг үгүйсгэхгүй бөгөөд илэрсэн тохиолдолд зохих шатны төрийн захиргааны байгууллагуудад мэдэгдэн, хадгалан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Нийгэм, эдийн засаг. Жуулчны бааз нь байнгын ажиллагаатай. Бааз нь захирал, нябо, байгаль орчны ажилтан, зохион байгуулагч, нярав, зөөгч, тогооч, бэлтгэгч, угаагч, гэрийн үйлчлэгч, харуул-сантехникч гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Хэмжээний орлого оруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байр бий болгосноор ажилчдын амьжиргааны түвшин дээшлэх, гадаад дотоодын аялагч, жуулчдад өндөр чанартай үйлчилгээ үзүүлж цэвэр агаар, үзэмжит байгалийн сайханд амрах алжаал тайлах нөхцлөөр хангах зэрэг болно.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРИЛГАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2024 ОН/

Хүснэгт № 2.

№	Хүрээндүүлийн орчин	Гол ба болзошгүй сөргөн нөлөөлөл	Үрьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хугацаа ба давталт	Нийт зардал /мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
1.	АГААРЫН ЧАНАР	Баазад ирсэн жуулчид хог хаягдлыг замбараагүй хаях	Орон нутгийн эрх бүхий газраас зааж тогтоосон газарт хог хаягдлыг цуглуулах цэгийг байгуулж байнгын ариутгал цэвэрлэгээ хийж ажиллах. Жуулчны баазын тодорхой тохиромжтой газруудад ангилсан хогийн савуудыг байршуулж тэмдэгжүүлэлтийг хийх	Үйл ажиллагааны туршид	150.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга
2.		Хог хаягдлын цэг болон цэвэрлэх байгууламжаас орчинд эвгүй үнэр гарах, амьдрах орчны тав тухыг алдуулахаас сэргийлэн байнга хяналт тавих	Хог хаягдлын цэг болон цэвэрлэх байгууламжаас орчинд эвгүй үнэр гарах, амьдрах орчны тав тухыг алдуулахаас сэргийлэн байнга хяналт тавих	Үйл ажиллагааны туршид	300.0	
3.	ХӨРСӨН БҮРХЭВЧ	Жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашигдагдахгүй байгаа 9 га талбайд хүний хөдөлгөөнийг хязгаарлах, элэгдэл эвдрэлд орохоос үрьдчилан сэргийлэх, тайланд тусгагдсан ногоон байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шинээр газар широоны ажил хийх үед газар хөндөх зөвшөөрлийн дотоод журмыг гарган нэвтрүүлэх	Жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашигдагдахгүй байгаа 9 га талбайд хүний хөдөлгөөнийг хязгаарлах, элэгдэл эвдрэлд орохоос үрьдчилан сэргийлэх, тайланд тусгагдсан ногоон байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шинээр газар широоны ажил хийх үед газар хөндөх зөвшөөрлийн дотоод журмыг гарган нэвтрүүлэх	Үйл ажиллагааны туршид	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний зардалд туссан	MNS 5914-2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах ерөнхий шаардлага
		Жуулчны баазад ирсэн зочдын хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвч талхлагдах, эвдрэлд орох. Нефть бүтээгдэхүүний асгаралтаас үрьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах ажлыг хэвшүүлэх	Жуулчны баазын тодорхой тохиромжтой газруудад хөрсөн бүрхэвчийг хамгаалах талаар анхааруулга, санамж бүхий самбар тэмдэгжүүлэлтийг хийх	Үйл ажиллагааны туршид	150.0	

№	Хүрээлэн буй орчин	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Үрьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хугацаа ба давталт	Нийт зардал /мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
4.	VC	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдсангаар хөрсөн бүрхэвчээр дамжин бага гүний усанд нөлөөлөх	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг байнга шалгах, хянах, эvdэrsэн тохиолдолд тухай бүр нэн даруй засвар, үйлчилгээ хийх	Үйл ажиллагааны туршид	200.0	MNS 4288:95, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус.
		Бохир усыг тухай бүрд нь тээвэрлэж зайлзуулаагүйгээс бохирын цооног халих, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлөх	Бохирын цооногийг стандартын дагуу барих, бохир усыг тухай бүрд нь тээвэрлэх, зайлзуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, байнга хяналт тавих	Үйл ажиллагааны туршид	200.0	
		Худгийн эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс бохирдох	Автомашин, дизель станцаас тос масло хөрсөн бүрхэвчийг нэвтэлж гадаргын болон гүний усанд нөлөөлөхгүй байхаар зохион байгуулах	Үйл ажиллагааны туршид	300.0	
5.	УРГАМЛАН НӨМРӨГ	Жуулчны баазийн төслийг хэрэгжүүлэх явцад 2018 онд 1600 м ² талбайд ногоон байгууламж, мод бүхий зуравс байгуулах ажлыг гүйцэтгэх	Зөвлөмжид заасны дагуу талхлагдалд өртөхөөс өмнө хамгаалах арга хэмжээ авах ба ургамалжилт болон хөрсний хэв шижиж нарийвчлан судлаж тухайн газар нутгийн хөрс, ургамлан нөмрөгт тохирсон нөхөн сэргээлтийн ажлыг хийх	Үйл ажиллагааны туршид	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний зардалд туссан	MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамалыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
6.		Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлэх, ургамал, амьтны хамгаалалт, зохисгүй ашиглалтыг хориглох талаар өөрийн ажиллагсад болон зочдод байнгын мэдээлэл сурталчилгаа хийж хэвшүүлэх				
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал					1300.0	

БҮЛЭГ III. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК-ийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан гүйцэтгэлээ. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 4 дүгээр хэсгийг баримтлан шинэчлэн боловсруулав.

Манай компани байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, БОАЖЯамаар хянуулж батлуулах, хэрэгжилтийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашилах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, ногоон байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардгахаа хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдал, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах албан тушаалтан, шинжилгээний арга, шаардгахаа зардлыг тооцож тусгасан.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж байгаа орчин, байгаль орчны төлөв байдал, төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаарх товч тодорхойлолт, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгасан.

Манай компани 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Налайх дүүргийн Засаг даргын тамгын газарт 12 сарын 01-ний дотор гаргаж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, БОАЖЯамаар дараагийн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан ажилана.

Манай компани жуулчны баазын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголд заасны дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд 2022 оны 09 дүгээр сард Байгаль орчны төлөвлөгөөт аудит мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт БОАЖЯаманд хүргүүлж байна.

3.1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК-ийн “Аянчин Лодж” жуулчны баазын төслийн 2023 онд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зарцуулах нийт зардал 7,650,800 төг байна.

БОМТ-ний зардлын хураангуй

Хүснэгт № 3.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1300.0
Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө, мян.төг	3450.8
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2900.0
БОМТ-ний нийт зардал	7650.8

3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

3.2.1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Манай компани нь жуулчны баазын барилга байгууламж, гадна орчны өнгө үзэмж, тохиижилтыг сайжруулах үүднээс термоблок бетонон барилга, гэр-тек модон барилга, зочид буудал, оффисын барилга, баазын зуны модон байшин, гэр буудал болон автомашины гаражны хооронд явган хүн замыг бетонон хучилттай болгож тохижуулсан.

Мөн жуулчны баазын дотор халаалтын болон халуун усны системийг өмнө нь Kiturami KRM 30/70 маркийн жижиг оврын зуухаар (нүүрс, дизель хосолсон) халаадаг байсан бол 2019 оны 10 сард “БАУХАУС” ХХК-аар цахилгаан эрчим хүчээр ажилладаг халаалтын болон халуун ус, цэвэр усны систем болгон бүхэлд нь сольж шинэчлэсэн.

2024 оны БОМТ-нд газар хөндөх дотоод хяналт зөвшөөрлийн журам хэвшүүлэх ажлыг тусгасан.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ)-т төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандарттууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. БОХШХ-ийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавараас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,

- Байгаль орчны хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг,
- Төслийн БОХТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

БОХШ-ийг хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11-р сарын дотор тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж хянуулан, дараа оны БОХШ-ийг батлуулах ёстой.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Жуулчны баазын тодорхой тохиромжтой газруудад ил задгай хог хаяхгүй байх анхааруулга, санамж бүхий самбар тэмдэгжүүлэлтийг хийх.

Хог хаягдлын цэг болон цэвэрлэх байгууламжаас орчинд эвгүй үнэр гарах, амьдрах орчны тав тухыг алдуулахаас сэргийлэн байнга хяналт тавих зэрэг болно.

2024 онд “Нийслэлийн агаарын бохирдол бууруулах газар”-тай албан ёсны гэрээ байгуулан амралтын газрын агаарын чанарыг хэмжүүлсэн.



Зураг №15 Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас
агаарын чанар шалгаж буй байдал

3.2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаа явагдахгүй байгаа 9 га талбайд хүний хөдөлгөөнийг хязгаарлах, элэгдэл эвдрэлд орохоос урьдчилан сэргийлэх, тайланд тусгагдсан ногоон байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

2024 оны хоол үйлдвэрэл, хүүхдийн тоглоомын талбай, хогын цэгийн ойр орчим гэсэн цэгүүдээс зориулалтын уутанд технологийн дагуу хөрсний дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлсэн.

Жуулчны баазын тодорхой тохиромжтой газруудад хөрсөн бүрхэвчийг хамгаалах талаар анхааруулга санамж бүхий самбар тэмдэгжүүлэлтийг хийх зэрэг болно.



Зураг №16 Хөрсний дээж авсан байдал

3.2.4. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Жуулчны баазад 70 м гүн өрмийн худагтай бөгөөд өдөрт хамгийн ихдээ 20 м³ ашигладаг. Ундаргаар нь тооцож үзэхэд өдөрт 43.2 м³ ус авч ашиглах боломжтой.

Худгийн эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоох, худагт байшин барьж ашиглах зэргээр сөрөг нөлөөллийг бууруулах, усны эх үүсвэрийг хамгаалах.

“Ханлаб” лабораторид цэвэр, болон бохир усны дээж өгч бүрэн шинжилгээнд хамруулсан болно. Унд ахуйн зориулалтаар гаргасан өрөмдмөл худгаас гадна хоногт 25 м³ бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжтай ба цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн усыг гэрээт “Чандмань Налайх” ОНӨААҮГ-аар тээвэрлүүлдэг.

Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг байнга шалгах, хянах, эвдэрсэн тохиолдолд тухай бүр нэн даруй засвар, үйлчилгээ хийх.

3.2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашиглагдахгүй 9 га талбайд хүний хөдөлгөөнийг хязгаарлах, элэгдэл эвдрэлд орохоос урьдчилан сэргийлэх, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ногоон байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын “Эрээний адаг” нэртэй газар хэрэгжиж буй “Аянчин Лодж” жуулчны баазын төслийг хэрэгжүүлэх явцад 2024 онд гүйцэтгэх ногоон байгууламжийн төлөвлөгөөг эдийн засгийн тооцооны хамт оруулав.

Тус ногоон байгууламжийг амжилттай тариалснаар байгаль орчинд эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ төсөл хэрэгжиж буй талбайн тодорхой хэмжээний хөрсийг хамгаалж элэгдэл эвдрэлд өртүүлэхгүй байх, төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад ач холбогдолтой.

2024 онд 1600 м² талбайд ногоон байгууламж, мод бүхий зурvas байгуулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгав. Ногоон байгууламж байгуулах талбай нь 8 м зурvas

бүхий мод, бут сөөг, 2 м өргөн зурвасаар явган зам болон үндсэн байгууламжийг тойруулан зурvas байгуулахаар төлөвлөж гүйцэтгэнэ.

Өөрийн ажиллагсад болон зочдод мэдээлэл сурталчилгаа хийж хэвшүүлэх. Энэ нь хууль бусаар ан хийх, ургамал түүх болон тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

3.3. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө

Жуулчны баазын өмнө гүйцэтгэсэн ногоон байгууламж

Тус компани нь барилга байгууламж, гадна орчны өнгө үзэмж, тохижилтыг сайжруулах үүднээс термоблок бетонон барилга, гэр-тек модон барилга, зочид буудал, оффисын барилга, баазын зуны модон байшин, гэр буудал болон автомашин грашны хооронд явган хүний замыг бетонон хучилттай болгож тохижуулсан байна.

Тус бааз нь ногоон байгууламжийг өмнө жилүүдэд хүүхдийн тоглоомын төвийн дээд талд 1000 м² талбайд, баазын зуны модон байшин, гэр буудлын хойд талд 1300 м² талбайд, оффисын барилгыг тойруулан **200 мкв талбайд гацуур** тариалсан байна.



Зураг №17. Баазын өмнө жилүүдэд гүйцэтгэсэн ногоон байгууламж

Жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа талбайгаас 2016-2023 онд 2000 м² талбайд мод бүхий зурvas, зүлэгжүүлэлт хийж ногоон байгууламжийн төлөвлөгөөг бодитойгоор хэрэгжүүлэн ажиллаа. Ногоон байгууламжид тарих ургамлыг сонгоходоо Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлангийн “Ногоон байгууламжийн төлөвлөгөө”-нд санал болгосон хувилбарын дагуу гүйцэтгэжээ.

Ногоон байгууламжийн төлөвлөгөөг бодитойгоор хэрэгжүүлэх үүднээс хөрсний хэв шинжид зохицсон мод, сөөг, олон наст ургамал сонгосон ба эдгээр нь дасан зохицол сайтай, жуулчны баазын талбайд ургах чадвартай нь нотлогдсон юм.

2023 онд суулгасан модны суулгац маань 98% нь цаашид ургах чадвартай байна.

2024 оны төлөвлөгөөний дагуу 200 ширхэг агч, шинэс зэрэг модны суулгацыг амжилттай тарьж суулгасан. Мөн 1000 м² талбайд олон наст ургамлаар зүлэгжүүлэлт хийжээ.



Зураг №18 2024 оны 05р сарын 26нд хамт олноороо
модны суулгац суулгаж буй нь



Зураг № 19. Олон наст модлог ургамал тариалсан байдал





Зураг № 20. Олон наст ургамлаар зүлэгжүүлэлт хийсэн байдал

Баазын ногоон байгууламжийн төлөвлөгөөний гол зорилго нь төсөл хэрэгжих газрын байгаль цаг уурын онцлогт тохируулан баазын эдэлбэр газарт ногоон байгууламжийг барьж байгуулах байсан юм. Энэхүү зорилготой уялдуулан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30дугаар зүйлийн 30.2 заалт, Ойн тухай хуулийн 13 зүйлийн 1.1 дэх заалт, дархан цаазат газрын хамгаалалтын нийтлэг горимын 9 дүгээр зүйлийг үндэслэн доорхи 6 байршилд 9.8 га / А.байршил 1.7 га, Б.байршил 1.7 га, В. Байршил 7.9 га, Г.байршил 1.5 га, Д.байршил 1.5 га, Е. Байршил 1.5 га / газрыг хариуцан байгаль хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх ажлыг хийж байна.

2016-2020 онд нийтдээ 540 суулгац модыг Жуулчны баазын эргэн тойронд үйл ажиллагаанд ашигдагдахгүй байгаа 2 га талбайд хийж гүйцэтгэсэн байна.





Зураг № 20. 540 суулгац мод тариалсан байдал

Ургамлын тогтвортой дасан зохицож ургаж болох эсэх нь багадаа 2-3 жилийн дотор харагддаг тул тухайн мод сөөгийг тариалж дууссанаас хойш байнга мониторинг судалгаа хийж явуулах бөгөөд жил бүр мод сөөгний ургалтыг хянан байнгын ажиглалт хийнэ.

3.3.1. Жуулчны баазын 2024

онд хэрэгжүүлэх нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө

Жуулчны баазийн төслийг хэрэгжүүлэх явцад 2023 онд шинээр 200 ширхэг модны суулгац тариалах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгав.

Ногоон байгууламж байгуулах талбай нь 8 м өргөн зурvas бүхий мод, сөөг, 2 м өргөн зурvasаар явган зам болон үндсэн байгууламжийг тойрч зурvas байгуулахаар төлөвлөсөн.



Зураг № 21. “Аянчин лодж” жуулчны баазын ногоон байгууламжийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зардлын тооцоог гаргахдаа “Цэцэрлэгжүүлэлт” компаниас гаргасан ургамлын үнийг харгалзан үзэж гаргав.

Нөхөн сэргээлтэд ихэвчлэн манай орны хээр, ойт хээр, хангайн бүс бүслүүрт ургах чадвартай мод сөөгийг сонгосон. Олон наст ургамлаар согооврыг сонгосон бөгөөд

согоовор нь манай оронд хамгийн сайн ургадаг, өргөн тархацтай, өвөлжилт хамгийн сайн даадаг ургамал юм. Согооврын үрийг 1 m^2 талбайд 25 гр орохоор тооцож гаргасан.

Ногоон байгууламжийн нь 2 эгнээ модлог ургамал, 1 эгнээ өвслөг ургамал гэсэн хэлбэрээр зохион байгуулагдана. Сөөг – Ургамал - Сөөг



Зураг 22. Нөхөн сэргээлтийн эхний хувилбарын зураглал

Шинэс, агч гэсэн 2 төрлийн суулгацыг сонгон авсан. Мод үржүүлгийн газар үрээр тариалан түүнийгээ **60-80** см болсон үед нь суулгадаг ба эрс тэс уур амьсгалыг даадаг, мөн гоёл чимэглэлд тохиромжтой мод юм.

Дээрх суулгацын хоорондын дасан зохицол сайн бөгөөд тариалах хугацаа, услах горим зэрэг болон ургах орчин нөхцлийн хувьд адилхан болно. Мөн эгнээ хоорондын зайд, мод хоорондын зайд зэргийг харгалзан үзэж, нэг хувилбар болгон сонгон авсан.

Ногоон байгууламжийн тооцоо

Хүснэгт № 4.

Нэр	Талбайн урт, м	Талбайн өргөн, м	Мод бүхий зурсас /ш/	Мод хоорондын зайд, м	Эгнээ хоорондын зайд, м	Нэг суулгацын үнэ, Т	Тарьц /ш/	Нийт үнэ /мян.төг/
Шинэс	60	12	2	2	2	8000	40	320.0
	24	8	2	2	2	8000	20	160.0
Агч	63	12	2	2	2	4500	90	405.0
	32	8	2	2	2	4500	50	225.0
Нийт дүн								1110.0

Хар шороо - 77 m^3 , 1 m^3 - 12500 төг, Нийт – 962.5 мян.төг

Усалгааны зардал: 579.5 мян.төг

Ногоон байгууламжийн нийт үнэ: 2651.5 мян.төг

Дээрх үнийн тооцоонд газар шорооны ажлын хөлс багтаагүй бөгөөд уг ажлыг баазийн ажилчид хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн тохиолдолд зардлыг нэмж тусгана.

Усалгааны зардлын тооцоо

Хүснэгт № 5.

Тарьц	Усалгаатай өдөр	1 тарьцын усны хэмжээ /л/*	Нийт тарьц, /ш/	Өдрийн усны хэмжээ /тн/	Жилийн усны хэмжээ /тн/	1 м ³ усны үнэ**	Усны үнэ (мян.төг /жил)
Шинэс	30	40	288	11.5	345	1001	345.3
Агч	30	40	196	7.8	234	1001	234.2
Нийт дүн							579.5

* БОНХАЖСайдын 2015 оны 7 дугаар сарын 30 оны өдрийн А-301 тоот тушаалын 13 дугаар хавсралтаар тооцов.

**Усны үнийг тооцоходоо Улаанбаатар хотын Ус сувгын удирдах газрын Бааз аж ахуйн, нэгж байгууллагаас авах усны тарифын үнийг баримтлав.

2024 онд Ногоон байгууламж байгуулах жилийн дундаж зардал 2651.5 мян.төг зарцуулах тооцоо гарч байна.

2024 оны нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 6.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хугацаа ба давталт	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
1.	НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Ногоон байгууламцийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2023 онд 200 ширхэг мод тариалах ажлыг гүйцэтгэнэ.	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгасан.	200	2651.5	MNS 5914-2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамалыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
НИЙТ ЗАРДАЛ					2651.5	

3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус жуулчны бааз нь Тус бааз нь Байгаль орчин, Аялал жуулчлалын яамнаас 2017 оны 09 сарын 07-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт ачлал жуулчлалын зориулалтаар газар ашиглах 0160853 дугаартай гэрчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 09 сарын 07 өдрийн A/263дугаартай тушаалаар 5 жилийн хугацаатай авсан бөгөөд төсөл хэрэгжүүлэх явцад нүүлгэн жилжүүлэх, нөхөн олговор арга байхгүй болно.

3.5. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Монгол улсын их хурлын 1993 оны 83-р тогтоол, Засгийн газрын 1994 оны 9-р тогтоолоор ГТБЦГ-ыг ХХТХГН-ийн Хамгаалалтын захиргаанд хариуцуулжээ. 1994 онд “Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн тухай” Монгол улсын хууль батлагдсантай уялдуулан Засгийн газрын 1995 оны 169-р тогтоолоор хамгаалалтын нийтлэг горим, хилийн заагийг шинэчлэн мөрдүүлсэн. 2013 оны 07 сард ХХТХГН-ийн хамгаалалтын захиргаанаас ГТБЦГ-ын хамгаалалтын захиргааг салгаж тус тусдаа болгосон.

Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6 дугаар хороо, Горхи –Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Эрээний адаг нэртэй газарт 12 га талбайд хэрэгжиж байна. [/Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах тоот гэрчилгээний хуулбарыг хавсаргав/](#).

2023 оны 09 сарын 25-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээг Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай гурвалсан гэрээг 2027 оны 09 сарын 07-ны өдөр хүртэл хугацаагаар хийсэн байна [/Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээний хуулбарыг хавсаргав/](#).

Төслийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйл, архиологи, палеонтологийн олдвор илрэхийг үгүйсгэхгүй бөгөөд илэрсэн тохиолдолд зохих шатны төрийн захиргааны байгууллагуудад мэдэгдэн, хадгалан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах болно.

3.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Жуулчны бааз нь хатуу хог хаягдлын цэгийг байгуулахдаа модон хавтан, төмөр дээврээр битүү байшин барьж хог хаягдлыг тээвэрлэх хүртэл орчинд эвгүй үнэр тархах, салхи, уснаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэж байна.



Зураг № 23. Хог хаягдал хадгалах байгууламж

Хог хаягдал хадгалах байшинг угсрахдаа 2 тасалгаатай барьсан бөгөөд том тасалгаанд дахин ашиглах боломжгүй хог хаягдал, жижиг тасалгаанд дахин боловсруулах боломжтой буюу дахивар бүтээгдэхүүнийг хадагладаг байна.

Хог хаягдал хадгалах байгууламж нь маш сайн битүүмжлэгдсэн бөгөөд нэг хүнээс хоногт дунджаар 1.5-2 кг хуурай хог хаягдал гарна гэж тооцож тусгай бэлтгэсэн тасалгаанд хадгалж тухайн хогийн хэмжээнээс шалтгаалан сард нэгээс доошгүй удаа /ачаалал ихтэй үед 7-14 хоног тутам/ зөөвөрлөн Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тэй байгуулсан “Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ”-ний дагуу зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлцуулан ажиллаж байна. **/Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээний хуулбарыг хавсаргав/.**

Баазаас гарах шингэн хог хаягдлын эх үүсвэрт гол тогооны бохир ус, цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус, бие засах газрын бохир ус, ариун цэврийн өрөөнүүдээс гарах бохир ус орно.


Баазын дотор болон гадаа шаардлагатай хэсэг тус бүрд ангилан ялгах хогын савуудыг хаягжуулан, байршуулсан.



Зураг №24 хог хаягдлын савнууд

Мөн хуванцар, шил, цаасыг тусад нь хуримтлуулан дахивар болгон тушааж хэвшсэнээр байгальд ээлтэй, мөн санхүүгийн нэмэлт орлоготой болж байна.

Хоол үйлдвэрлэл, цэвэрлэгээ үйлчилгээний бодис, бүтээгдэхүүний сав баглааг тогтмол ангилан ялгаж хэвшсэн.





“Аянчин Фоор Сийзонз Лодж” ХХК

3.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Үйл ажиллагаатай холбоотой аюул, осол эрсдэлийг бууруулах зорилгоор Налайх дүүргийн Онцгой байдлыг газар, Гал түймэр унтраах аврах ангитай хамтран 2024 оны 9р сарын 13 нийт өдөр нийт ажилтнууд гамшигаас урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдсан.



Зураг №25 Гамшигаас урьдчилан сэргийлэх сургалт

3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ)-т төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. БОХШХ-ийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Ахн таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавараас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,
- Байгаль орчны хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,

- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг,
- Төслийн БОХТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

БОХШ-ийг хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11-р сарын дотор тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж хянуулан, дараа оны БОХШ-ийг батлуулах ёстой.

2024 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт № 7.

№	Хүрээлэн буй орчин	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ явуулах хугацаа болон давтамж	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
1.	Жуулчны бааз	Төслийн үе шатанд хэрэглэгдэж буй дизель, шатах тослох материалын хадгалалт, тээвэрлэлтын үсийн бүрэн бүтэн байдал, шүүрэл асгаралтын байдал, хадгалах орчны горим, параметрууддэд үзлэг шалгалт хийх	Жуулчны бааз	Үйл ажиллагааны туршид	Цалингийн санд	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химиин хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм. БНБД 21-02 -02
2.	Агаарын чанар	Хүхрийн исэл SO2 Нүүрстөрөгчийн дутуу исэл CO Азотын исэл NOx Тоос (SPM) Хар тугалга РВ Бензапирен	Баазын салхины зонхилох чиглэлийн дагууд (ЗУ, БХ) 100, 200, 300, 500 метр зайд	Жилд 1 удаа 2 цэгээс	351.7	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга
3.	Хөрсон бүрхэвч	pH, ялзмагийн агууламж, ялзмагт давхаргын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, хүнд металууд, 1 см ³ дэхь бактери, эмгэг төрүүлэгч бичил биетэн байгаа эсэх	Баазын гадна талбай, хэрэв бохирдол үүссэн бол түүний орчимд	Жилд 1 удаа 2 цэгээс	800.0	MNS 3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах ерөнхий шаардлага

4.	ҮС	Цэвэр ус: Ерөнхий хатуулаг, Урвалын орчин /рН/, Ислдэх чанар, Тунгалагшил, Өнгө, Үнэр, Амт, Тунадас Анион Cl ⁻ , SO ₄ ²⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ²⁻ , HCO ₃ ⁻ / Эаёеий /Na ⁺ + K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ /	Төвлөрсөн шугамаар ирж буй ус	Жилд 2 удаа	700.0	MNS 0900 - 2005 , Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0017-1-1-14:1980 Уст мандал. Усны ашиглалтын ангилал. Ерөнхий шаардлага MNS 4288:95, Бөхир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага, MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус.
		Бохир ус: Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /BXX ₅ /, Химийн хэрэгцээт хүчилтөрөгч /XXX/, Жинлэгдэх бодис, Өөх тос, Нийт азот	Баазын хаягдал бохир ус	Жилд 2 удаа	800.0	
НИЙТ ЗАРДАЛ				2900.0		

3.8. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОАЖЯ-д тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

2024 онд Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөг тайлagnах хугацаа

Хүснэгт № 8.

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлagnах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах эзэн
